




МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ИРГЭДИЙН ИНФЛЯЦЫН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА

2026 оны II улирал

2026 оны 7 дугаар сар




I. ХУРААНГУЙ

Улсын инфляцыг 2025 оны III улирлаас эхлэн бодлогын шийдвэрт ашиглаж эхэлсэнтэй уялдуулж, 2025 оны IV улирлын судалгаанаас эхлэн хамрах хүрээг улсын хэмжээнд болгон өргөжүүлсэн билээ. Энэ удаагийн судалгааг мөн улсын хэмжээнд 2026 оны 6 дугаар сарын 9-21-ний өдрүүдэд зохион байгуулж, Монгол Улсад оршин суугаа нийт хүн амын байршил, хүйс, насны бүлэг, өрхийн орлогын бүтцийг төлөөлөх нийт 1,790 иргэд судалгаанд хамрагдлаа. Судалгааны голлох үр дүнг дараах байдлаар нэгтгэн танилцуулж байна.

- Судалгаанд 26-55 насны дээд боловсролтой, эмэгтэй иргэд түлхүү оролцлоо.
- Түүвэр судалгаанд хамрагдсан иргэдийн хариултад үндэслэн хүлээгдэж буй инфляцын түвшнийг медиан утгаар тооцоход ирэх 3 сард (2026 оны III улирлын эцэст) одоогийн түвшнээс бага зэрэг буюу 0.4 нэгж хувиар өсөж **11.6%**-тай байна. Харин 2026 оны эцэст **12.1%**, ирэх 12 сарын хувьд (2027 оны II улирлын эцэст) өмнөх улирлын утгаас ойролцоогоор 1.3 нэгж хувиар нэмэгдэж, инцляц одоогийн түвшнээс нэмэгдэх хүлээлттэй гарлаа. Ийнхүү инфляцын хүлээлт ирэх 1 жил орчмын турш зорилтот түвшний дээд интервалаас өндөр хадгалагдаж жилийн дараа **12.5%** болж нэлээд өндөр байх төлөвтэй байна (Зураг 1).
- Улаанбаатар хотод инфляцыг харьцангуй өндөр буюу ирэх 3 сард **12.0%**, ирэх 12 сард **13.5%**-тай байна гэсэн хүлээлттэй байна.
- 2026 оны III улиралд өрхийн орлогын хүлээлт өмнөх улирлаас нэлээд саарах хүлээлттэй байгаа бол зардлын хүлээлт тогтвортой өсөх хүлээлт хэвээр байна. Өрхийн хуримтлалын хүлээлт муудсан дүр зурагтай хэвээр гарлаа.
- Иргэдийн дунд ажил эрхлэлт бага зэрэг буурах хүлээлт давамгайлж байна. Мөн эдийн засаг удаашрах, төгрөгийн ханш үргэлжлэн сулрах, зээлийн хүү нэмэгдэх хүлээлттэй гарлаа.
- Мөн иргэд сүүлийн 2 улирал дараалан мөнгөний бодлогын төлвийг чангарна гэж хүлээж байна.

Зураг 1. Инфляцын хүлээлт




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

I. ИНФЛЯЦЫН ХҮЛЭЭЛТ


Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн чанарын хариултад үндэслэн өнгөрсөн хугацааны үнийн мэдрэмжийн индексийг тооцоход өнгөрсөн 3 болон 12 сарын хугацааны хувьд өмнөх улирлын судалгааны үр дүнгээс бага зэрэг өсөж “инфляц өссөн” мужид хэвээр хадгалагдлаа. Өөрөөр хэлбэл, иргэдийн дунд үнийн өсөлтийн талаарх мэдрэмж өндөр хэвээр байна (Зураг 2).

Мөн ирэх хугацааны инфляцын хүлээлтийн индексийг тооцоход ирэх улирлын болон ирэх 1 жилийн хүлээлтийн индексийн утгууд өмнөх улирлаас бага зэргийн буурсан хэдий ч индексийн утга тус бүр “инфляц өснө” мужид хэвээр хадгалагдлаа (Зураг 3).

Зураг 2. Инфляцын мэдрэмжийн индекс¹



Зураг 3. Инфляцын хүлээлтийн индекс




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Ирэх хугацааны инфляцын хүлээлтийн тоон хариултад үндэслэн дундаж утгыг тооцоход 2026 оны III улиралд **10.4%** гарсан бол медиан² утга **11.6%**-тай байна. Эдгээр нь өмнөх улирлын үр дүнгээс 2.6-3.7 нэгж хувиар өссөн үзүүлэлт бөгөөд ирэх улиралд зорилтот түвшнээс нэлээд давах хүлээлттэй байна. Инфляцын хүлээлтийн утга 2025 оны туршид дараалан буураад байсан бол 2026 он гарсаар сүүлийн 2 улирал дараалан нэмэгдээд байна (Зураг 4). Иргэдийн ирэх 3 сарын инфляцын хүлээлтийн тархалт өмнөх улиралтай харьцуулахад баруун тийш шилжиж, өндөр инфляцын интервалд төвлөрөх хандлага нэмэгдлээ. Тоон хариултын дийлэнх хэсэг 2026 оны I улиралд 7-9 хувийн интервалд төвлөрч байсан бол 2026 оны II улиралд 11-13 хувийн интервалд хамгийн өндөр давтамжтай болжээ (Зураг 5). Энэ нь иргэдийн богино хугацааны инфляцын хүлээлт нэмэгдэж, инфляц ойрын хугацаанд одоогийн өндөр түвшинд хадгалагдах, эсвэл нэмэгдэх эрсдэлийг илүү өндөр гэж үнэлж байгааг илтгэнэ.


¹ Бараа, үйлчилгээний үнийн ерөнхий түвшин өнгөрсөн хугацаатай харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн талаар мэдрэмжийг асууж, “маш ихээр өссөн”, “нэлээдгүй өссөн”, “аажмаар өссөн”, “хэвэндээ” болон “буурсан” гэсэн хариултуудыг [3;-1] утгаар нормчилж чиглэлийн индексийг тооцсон болно.

² Тоон асуулгын хариултаас [Nicholas J. Cox \(2009\)](#)-ийн боловсруулсан “Хагас тархалтын функц” болон “Симметрик шугаман интерполяци медиан” аргачлалыг ашиглан тоон хүлээлтийн тархалт болон медиан утгыг тооцсон болно.

Зураг 4. Тоон хариултаас тооцсон инфляцын хүлээлтийн медиан болон дундаж утга, ирэх 3 сар




Зураг 5. Инфляцын хүлээлтийн тоон хариултын тархалт, ирэх 3 сар




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Инфляцын хүлээлтийн тоон хариултын дундаж утга 2026 оны эцэст³ **12.1%**, медиан утга **11.1%**-тай гарлаа (Зураг 6). Энэ оны эцэст инфляцын хүлээлтийн тархалтын хувьд 11%-13% орчимд төвлөрчээ (Зураг 6).

Зураг 6. Тоон хариултаас тооцсон инфляцын хүлээлтийн медиан болон дундаж утга, 2026 оны эцэс



Зураг 7. Инфляцын хүлээлтийн тоон хариултын тархалт, 2026 оны эцэст




Түүнчлэн 2027 оны II улирлын инфляцын хүлээлтийн дундаж утга **11.7%** гарсан бол медиан утга **12.5%**-тай гарсан буюу жилийн дараа зорилтот түвшнээс нэлээд давах хүлээлттэй байна (Зураг 8). Ирэх 12 сарын инфляцын хүлээлтийн тархалт өмнөх улиралтай харьцуулахад баруун тийш шилжиж, арай өндөр инфляцын интервалд төвлөрчээ. 2026 оны I улиралд хариултууд голчлон 7-11 хувийн орчимд төвлөрч, харьцангуй жигд хэлбэртэй байсан боловч энэ улиралд


³ Тухайн оны эцсийн байдлаар инфляцын хүлээлтийг тайлант улирлаас эхлэн асуулгад нэмж, шинээр тусгасан болно.

хариултын давтамж 11-17 хувийн интервалд илүү өндөр болсон байна. Өөрөөр хэлбэл, хариултууд өндөр инфляцын өргөн интервалд тархсан нь иргэдийн дунд инфляцын цаашдын төлөвийн талаарх тодорхой бус байдал нэмэгдэж байгааг харуулж байна (Зураг 9).

Зураг 8. Тоон хариултаас тооцсон инфляцын хүлээлтийн медиан болон дундаж утга, ирэх 12 сар




Зураг 9. Инфляцын хүлээлтийн тоон хариултын тархалт, ирэх 12 сар



Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Инфляцын хүлээлтийн чанарын хариултад үндэслэсэн тархалтаас харахад 2026 оны II улиралд иргэдийн дунд үнэ цаашид өснө гэсэн хүлээлт давамгайл хэвээр байна. Тухайлбал, нийт оролцогчдын 48 хувь нь үнэ “өнөөгийн түвшнээс илүү өснө”, 29 хувь нь “ижил хувиар өснө”, 16 хувь нь “багаар өснө” гэж хариулсан бөгөөд нийтдээ 93 хувь нь үнийн өсөлт үргэлжилнэ гэж үзжээ. Өмнөх улиралтай харьцуулахад “өнөөгийн түвшнээс илүү өснө” гэсэн хариултын эзлэх хувь 16 нэгж хувиар буурсан боловч “ижил хувиар өснө” болон “багаар өснө” гэсэн хариултын хувь нэмэгдсэн байна. Өөрөөр хэлбэл, иргэдийн инфляцын хүлээлт өндөр хэвээр байгаа ч үнийн өсөлтийн эрчим өмнөх улирлаас бага зэрэг саарах хүлээлт нэмэгджээ. Харин “үнэ хэвээр байна” болон “үнэ буурна” гэсэн хариултууд нийтдээ 7 хувийг эзэлж байгаа нь иргэдийн дунд инфляц ойрын хугацаанд буурах хүлээлт сул хэвээр байна (Зураг 10).


Зураг 10. Инфляцын хүлээлтийн чанарын хариултын тархалт, ирэх 3 сар



Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Мөн ирэх 12 сарын инфляцын хүлээлтэд үнэ өснө гэсэн хариулт давамгай хэвээр байна. 2026 оны II улиралд нийт оролцогчдын 57 хувь нь үнэ “өнөөгийн түвшнээс илүү өснө” гэж хариулсан нь өмнөх улирлаас 16 нэгж хувиар буурсан үзүүлэлт болж байна. Гэсэн хэдий ч “ижил хувиар өснө” болон “багаар өснө” гэсэн хариултыг хамруулбал иргэдийн 97 орчим хувь нь ирэх нэг жилийн хугацаанд үнэ өснө гэж үзсэн хэвээр байна. Үнийн өсөлтийн эрчим саарах хүлээлт тодорхой хэмжээнд нэмэгдсэн ч инфляцын хүлээлт өндөр түвшинд хадгалагдаж байна (Зураг 11).


Зураг 11. Инфляцын хүлээлтийн чанарын хариултын тархалт, ирэх 12 сар




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Иргэдийн инфляцын хүлээлт Улаанбаатар хот болон орон нутагт аль алинд нь зорилтот түвшнээс өндөр байна. Ирэх 3 сарын инфляцын хүлээлт 2026 оны II улиралд Улаанбаатар хотод **11.0%**, орон нутагт **9.8%**-тай байсан бол ирэх 12 сарын хүлээлт харгалзан **12.7%**, **10.8%**-тай гарлаа (Зураг 12, Зураг 13). Бүс нутгаар харьцуулахад Улаанбаатар хотын иргэдийн хүлээлт орон нутгийнхаас ирэх 3 сард 1.2 нэгж хувиар, ирэх 12 сард 1.9 нэгж хувиар өндөр байгаа нь хэрэглээний бүтэц, байр сууцны зардал, үйлчилгээ болон хүнсний үнийн ялгаатай холбоотой байж болзошгүй юм.

Зураг 12. Инфляцын хүлээлтийн дундаж утга, байршлаар (ирэх 3 сар)




Зураг 13. Инфляцын хүлээлтийн дундаж утга, байршлаар (ирэх 12 сар)




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Ирэх хугацааны инфляцын хүлээлтийг насны бүлгээр харьцуулахад бүх насны бүлэгт өмнөх улирлаас нэмэгдлээ. Тодруулбал, ирэх 3 сард 55-с дээш настай иргэдийн хувьд 2.7, 36-55 насны бүлэгт 2.2, 36-с доош насны бүлэгт 2.9 нэгж хувиар тус тус өсөж харгалзан **11.3%**, **10.2%** болон **10.1%** гарлаа (Зураг 14). Ирэх 12 сарын инфляцын хүлээлтийн хувьд өмнөх улирлаас мөн нэмэгдэж, ирэх 3 сарын хүлээлтийн утгаас насны бүлэг тус бүрт 2.7 орчим нэгж хувиар өндөр гарлаа (Зураг 15).

Зураг 14. Инфляцын хүлээлтийн дундаж утга, насны бүлгээр (ирэх 3 сар)




Зураг 15. Инфляцын хүлээлтийн дундаж утга, насны бүлгээр (ирэх 12 сар)




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Инфляцын хүлээлтийн утгыг орлогын ангиллаар харахад ирэх улиралд 1.6 сая төгрөгөөс доош орлоготой иргэдийн хүлээлт 3.3 нэгж хувиар өсөж **10.1%**, 1.6-3.0 сая төгрөгийн орлоготой иргэдийн хүлээлт 2.1 нэгж хувиар өсөж **10.7%**, 3.0 сая төгрөгөөс дээш орлоготой иргэдийн хүлээлт 2.5 нэгж хувиар өсөж **10.5%**-тай гарлаа (Зураг 16). Харин ирэх 12 сарын буюу 2027 оны II улиралд 1.6 сая төгрөгөөс доош орлоготой иргэдийн хүлээлт 3.4 нэгж хувиар, 1.6-3.0 сая төгрөгийн орлоготой иргэдийн хүлээлт 2.3 нэгж хувиар, 3.0 сая төгрөгөөс дээш орлоготой иргэдийн хүлээлт 2.5 нэгж хувиар тус тус өсөж, харгалзан **11.8%**, **11.5%**, **11.8%**-тай гарлаа (Зураг 17).

Зураг 16. Инфляцын хүлээлтийн дундаж утга, орлогын ангиллаар (ирэх 3 сар)



Зураг 17. Инфляцын хүлээлтийн дундаж утга, орлогын ангиллаар (ирэх 12 сар)




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа


II. ӨРХИЙН САНХҮҮГИЙН БАЙДАЛ

Өрхийн орлогын болон зардлын хүлээлтүүд 2024 онд оргилдоо хүрч, түүнээс хойш буурах хандлагатай байна. Өрхийн орлогын хүлээлт 2026 оны III улиралд өмнөх улирлаас нэлээд саарах хүлээлттэй байгаа бол зардал тогтвортой өсөх хүлээлттэй хэвээр байна. Хүлээлтийг гүйцэтгэлтэй харьцуулахад харьцангуй нийцтэй байгааг орлогын хүлээлтийг бодит цалингийн индекстэй, зардлын хүлээлтийг эцсийн хэрэглээний өсөлттэй харьцуулснаас харж болохоор байна (Зураг 18, Зураг 19).

Зураг 18. Өрхийн орлогын хүлээлт, ирэх 3 сар



Зураг 19. Өрхийн зардлын хүлээлт, ирэх 3 сар




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, УСХ

Өрхүүдийн хадгаламжийн хүлээлт сүүлийн 9 улирал дараалан буурах чиглэлд гарлаа (Зураг 20). Үүнийг бодит гүйцэтгэлтэй харьцуулан авч үзэхийн тулд өрхийн санхүүгийн тэнцлийг авч үзэх шаардлагатай. Өрхийн орлого бага зэрэг нэмэгдсэн боловч өрхийн санхүүгийн тэнцэл алдагдалтай хэвээр байна. Тухайлбал 2025 оны жилийн эцсийн байдлаар өрхийн санхүүгийн тэнцэл дунджаар 90.8 мянган төгрөгийн алдагдалтай байна. Иргэдийн хугацаатай хадгаламж 2026 оны I улирлын эцэст 21.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 11.2 хувиар өсөөд байна. Харин банкуудаас авсан иргэдийн хэрэглээний зээлийн үлдэгдэл мөн үеийн байдлаар 13.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9 орчим хувиар өссөн. Нөгөө талаас чанаргүй зээлийн эзлэх хувь өмнөх улирлаас 0.2 нэгж хувиар өсөж 5.1% буюу сүүлийн 7 улиралд тасралтгүй өссөнөөр 2021 оны түвшинд хүрлээ. Өөрөөр хэлбэл, хадгаламжийн өсөлт эерэг хандлагатай байгаа хэдий ч хэрэглээний зээлийн чанар муудаж буй нь өрхүүдийн санхүүгийн эмзэг байдал нэмэгдэж байж болзошгүйг илтгэж байна.

Ирэх улиралд санхүүгийн байдлаа төлөвлөхөд хүндрэлтэй байна гэж судалгаанд оролцогчдын дийлэнх нь үзэж байна. Энэ нь эдийн засгийн тодорхой бус байдал өндөр хэвээр байгааг илтгэнэ (Зураг 21). Хүлээлтийг зээлийн дундаж төлбөрийн орлогод эзлэх хувьтай харьцуулан үр дүнгийн нийцтэй байдлыг харвал өрхийн орлогод эзлэх зээлийн дарамт сүүлийн 2 жилийн хугацаанд дунджаар 22-25% орчим байгаа нь өрхүүдэд санхүүгээ төлөвлөхөд хүндрэл учруулсаар байна. Тухайлбал, иргэдийн банкнаас авсан хэрэглээний зээлийн үлдэгдэл, түүний жигнэсэн дундаж хүү болон хугацаагаар зээлийн сарын дундаж төлбөрийг тооцоход 2026 оны

I улирлын байдлаар 703.8 мянган төгрөг болж байна. Энэ нь өрхийн сарын дундаж нэрлэсэн орлогын⁴ 23.4%-тай дүйцэж байна.

Зураг 20. Өрхийн хадгаламжийн хүлээлт, ирэх 3 сар



Зураг 21. Санхүүгийн байдлын төлөвлөлт, ирэх 3 сар




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, Монголбанк, ҮСХ


III. МАКРО ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААРХ ИРГЭДИЙН ХҮЛЭЭЛТ

Ажил эрхлэлтийн талаарх хүлээлтийн үзүүлэлт өмнөх улирлын утгаас бага зэрэг буурч, ирэх улиралд ажил эрхлэлт буурах төлөвт гарлаа (Зураг 22). ҮСХ-ны мэдээгээр ажиллагчдын тооны өсөлт сүүлийн 3 улирал дараалан буурч, өмнөх оны мөн үес 3.5%-иар буурсан үзүүлэлттэй байна. Мөн эдийн засгийн өсөлтийн хүлээлтийн үзүүлэлт өмнөх улирлаас 0.1 нэгжээр өсөж -0.26 утгатай буюу эдийн засаг агших хүлээлттэй гарлаа (Зураг 23).

Зураг 22. Ажил эрхлэлтийн хүлээлт, ирэх 3 сар



Зураг 23. Эдийн засгийн байдлын талаарх хүлээлт, ирэх 3 сар



Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, ҮСХ

⁴ ҮСХ, “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”, 2025 оны IV улирал


2026 оны II улиралд 1 ам.доллар дунджаар 3,575.2 төгрөгтэй тэнцэж, ханш өмнөх оны мөн үеэс өөрчлөгдөөгүй байна. Харин төгрөгийн ханш ирэх улиралд суларна гэж иргэдийн дийлэнх үзсэн хэвээр байна (Зураг 24).

Зээлийн хүүний хувьд ирэх улиралд хүү өсөх хүлээлт иргэдийн дунд давамгайлсан хэвээр байгаа хэдий ч өмнөх улирлын утгаас бага зэрэг буурлаа (Зураг 25). Иргэдэд банкнаас олгосон хэрэглээний зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх улирлаас 0.2 нэгж хувиар өсөж 2026 оны II улирлын байдлаар 17.6%-тай байна.

Зураг 24. Гадаад валютын ханшийн хүлээлт, ирэх 3 сар




Зураг 25. Зээлийн хүүний талаарх хүлээлт, ирэх 3 сар



Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, Монголбанк

Төв банкны бодлогын хүү сүүлийн 6 улирал дараалан тогтвортой 12% байна. Харин иргэд 2026 оны III улиралд бодлогын хүүг⁵ өсөх (мөнгөний бодлогын төлөв чангарах) хүлээлттэй байгаа бөгөөд хүлээлтийн утга өмнөх улирлаас бага зэрэг буурлаа (Зураг 26).

Зураг 26. Бодлогын хүүний хүлээлт, ирэх 3 сар




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, Монголбанк

⁵ Ирэх улирлын мөнгөний бодлогын төлөвийн хүлээлтийн талаарх асуултыг 2026 оны I улирлын судалгаанаас эхлэн асуулгад нэмж, шинээр тусгасан болно.

IV. ХАВСРАЛТ

“Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа”-г 2026 оны 6 дугаар сарын 8-19-ний өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулж, өмнөх улирлуудын судалгаанд оролцож байсан насанд хүрсэн иргэдээс утсаар ярилцлага хийх байдлаар (786), орон нутгийн иргэдээс ярилцлага хийх байдлаар (917) болон дурын утасны дугаарлалт үүсгэж⁶ масс мессеж илгээх байдлаар буюу санамсаргүй түүвэрлэлтээр (87) цуглуулсан бөгөөд нийт 1,790 иргэдээс судалгааны мэдээлэл цуглууллаа. Судалгаанд оролцсон эдгээр иргэд нь улсын хэмжээнд эх олонлогоо бүрэн төлөөлөх чадвартай байна. Тухайлбал, судалгаанд оролцогчдын оршин суугаа хаягийг ҮСХ-оос зарласан 2025 онд Улаанбаатарт оршин суугаа хүн ам (насанд хүрсэн иргэд)-ын бүтэцтэй харьцуулахад харгалзан пропорциональ байна (Зураг 27). Орон нутгийн аймгууд тус бүр 4%-6% хувийг бүрдүүлээ (Зураг 28). Энэ удаагийн судалгаанд оролцогчдын 59% нь эмэгтэй, 41% нь эрэгтэй байна.

Зураг 27. Судалгаанд оролцогчдын оршин суугаа дүүрэг, эзлэх хувиар



Зураг 28. Судалгаанд оролцогчдын оршин суугаа аймаг, эзлэх хувиар




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, ҮСХ


Мөн судалгаанд оролцогчдыг насны ангиллаар харвал 26-55 насны иргэд 73%-ийг бүрдүүлсэн бөгөөд энэхүү насны бүлэг нь Монгол Улсад оршин суугаа нийт хүн амын 61%-ийг бүрдүүлдэг буюу насны бүлэг тус бүр харгалзан нийцтэй байна. Боловсролын хувьд дээд болон бүрэн дунд боловсролтой иргэд тус судалгаанд түлхүү хамрагдлаа (Зураг 29, Зураг 30).

⁶ “Random Digit Dailing” аргачлалыг 2025 оны 2 улирлын түүвэр судалгаанаас эхлэн ашиглаж байгаа бөгөөд энэхүү аргачлалаар түүврийн тодорхой хэсгийг бүрдүүлснээр судалгаанд оролцогч иргэдийн мэдээллийг шинэчлэх, шинэ оролцогчдыг элсүүлж, мэдээллийн санг өргөжүүлэх, насны бүлгийн залуу төлөөллүүдийн хувьд судалгаанд оролцох магадлалыг нэмэгдүүлэх, түүвэр судалгааны мэдээлэл цуглуулах цаг хугацаа, зардал хэмнэх зэрэг давуу талтай байна. Одоогоор нийт түүврийн 10 хүртэл хувийг энэхүү аргачлалаар мэдээлэл цуглуулахыг зорьж байна.

Зураг 29. Судалгаанд оролцогчдын насны ангилал



Зураг 30. Судалгаанд оролцогчдын боловсролын байдал




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, ҮСХ

Ажил эрхлэлтийн хувьд энэ удаагийн судалгаанд хувийн болон төрийн байгууллагад ажилладаг иргэд голлон хамрагдлаа (Зураг 31). Судалгаанд оролцогч иргэдийн өрхийн орлогын бүлэг нь ҮСХ-оос зохион байгуулдаг “Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа”-ны өрхүүдийг мөнгөн орлогоор бүлэглэсэн хамгийн сүүлийн буюу 2025 оны IV улирлын үр дүнтэй харгалзан нийцтэй байна (Зураг 32).

Зураг 31. Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлт



Зураг 32. Судалгаанд оролцогчдын орлогын бүлэглэлт



Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, ҮСХ